

АРИЛЖААНЫ ТАНХИМЫН ДОТООД ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь ХАА-н Бирж дээр явагдаж буй арилжааг холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд зохион байгуулах, арилжааны танхимд арилжааны дэгийг тогтоон мөрдүүлэхэд оршино.
- 1.2. Энэхүү журамд орсон нэр томъёог дор дурдсан утгар ойлгоно.
 - 1.2.1. Арилжаанд оролцогч: Арилжаанд оролцох эрх бүхий гишүүн компанийн арилжигч.
 - 1.2.2. Арилжаа хөтөгч: Арилжааг зохион байгуулж явуулах чиг үүрэг бүхий арилжааны албаны ажилтан.
 - 1.2.3. Арилжаа хянагч: Арилжаанд оролцогчдын арилжааны явцыг хянах чиг үүрэг бүхий хяналтын албаны ажилтан.
- 1.3. Энэхүү журмын хавсралт нь журмын салшгүй нэг хэсэг байна.

Хоёр. Арилжаанд оролцогч

- 2.1. Арилжааны үед арилжаанд оролцогч нь дараах эрх, үүрэгтэй болно. Үүнд :
 - 2.1.1. Арилжаа хөтлөгч, арилжаа хянагчийн зүгээс тавьсан шаардлагыг бүрэн биелүүлэх;
 - 2.1.2. Арилжааны үед гар утсаа унтраах;
 - 2.1.3. Арилжаанд оролцогч нь арилжааны үед терминал дээрх эд хогшлын бүрэн байдлыг хариуцах;
 - 2.1.4. Арилжаанд оролцогч зөвшөөрөгдсөнөөс бусад цагуудад арилжааны танхимд нэвтрэхгүй байх;
 - 2.1.5. Арилжаанд оролцогч арилжааны явцад бусдад саад учруулахаар чанга дуугаар ярих, бусад арилжаанд оролцогчийн дэлгэцийг харахгүй байх болон арилжааны хянагчийн зөвшөөрөлгүйгээр ажлын байрнаас босч явахгүй байх;
 - 2.1.6. Арилжаанд оролцогч арилжааны танхимын техник хэрэгсэл, программ хангамжыг зориулалтын бус зорилгоор ашиглахгүй байх;
 - 2.1.7. Танхимын арилжаанд оролцохдоо оролцогчид Хөдөө Аж Ахуйн Биржийн лого бүхий хантаазыг өмсөнө. (цайвар цамцтай ирнэ).

Гурав Арилжаа хөтлөгч

- 3.1. Арилжааны үед арилжаа хөтлөгч нь дараах эрх, үүрэгтэй болно. Үүнд:
 - 3.1.1. Арилжаа хөтлөгч арилжааны программын эрхийг нээж, цанг 1 удаа цохих;
 - 3.1.2. Албан ёсны арга хэмжээний үеэр байгууллагын удирдлагууд болон зочид нэвтрэхээс бусад тохиолдолд Арилжаа хөтлөгч арилжааны танхимд зөвшөөрөлгүй хүн нэвтрүүлэхгүй байх;
 - 3.1.3. Арилжааны явцад программ хангамжийн болон бусад аливаа саатал гарвал албаны захирал болон холбогдох ажилтанд яаралтай мэдэгдэх;
 - 3.1.4. Арилжаа дуусахаас 5 минутын өмнө арилжаа дуусах хугацааг арилжаанд оролцогчдод мэдээллэх;

3.1.5. Арилжааны үндсэн цаг дуусахад арилжааг хааж, цанг 1 удаа цохих.

Дөрөв. Арилжаа хянагч

- 5.1. Арилжааны үед арилжаа хянагч нь дараах эрх, үүрэгтэй болно. Үүнд:
 - 5.1.1. Холбогдох зааврын дагуу арилжааны бэлтгэл ажлыг бүрэн хангах;
 - 5.1.2. Арилжаа эхлэхээс өмнө арилжаанд оролцогчдын тус өдрийн захиалгын жагсаалтыг хүлээн авах;
 - 5.1.3. Арилжаанд оролцогчид тус өдрийн захиалгын жагсаалтын дагуу захиалгаа шивж буй эсэхийг хяналтын дэлгэцээр хянах;
 - 5.1.4. Арилжаанд оролцогч нь холбогдох дүрэм журмыг зөрчсөн нь тогтоогдвол өөрийн эрх мэдлийн хүрээнд зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;
 - 5.1.5. Арилжааны явцад техникийн болон программ хангамжын аливаа саатал гарвал энэ тухай саатал эхэлсэн болон дууссан цаг минутаар тэмдэглэл хөтлөх.

Тав. Арилжаанд оролцогчдод хориглох зүйлүүд

- 5.1 Арилжаа хөтлөгч арилжааны явцад ажлын байрыг зөвшөөрөлгүй ороыг хориглоно.
- 5.2 Албан ёсны арга хэмжээний үеэр байгууллагын удирдлагууд болох зочид нэвтрэхээс бусад тохиолдолд Арилжаа хөтлөгч арилжааны танхимд зөвшөөрөлгүй хүн нэвтрүүлэхийг хориглоно.
- 5.3 Арилжаа хянагч, арилжаа хөтлөгч нар арилжааны явцад ажлын бус шаардлагаар арилжаанд оролцогчтой харилцах, тэдэнд саад учруулахыг хориглоно.
- 5.4 Арилжаанд оролцогч зөвшөөрөгдснөөс бусад цагуудад арилжааны танхимд нэвтрэхийг хориглоно.
- 5.5 Арилжааны оролцогч арилжааны үед танхимыг зөвшөөрөлгүй орхиж явахыг хориглоно.